

ЗАСГИЙН ГАЗРААС АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР 2017-2020  
ОНД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ҮР НӨЛӨӨ

**ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

УЛААНБААТАР ХОТ  
2020 ОН

## АГУУЛГА

Аудитын нэр.....	3
Аудитын код.....	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх .....	3
Аудитын зорилт .....	3
Аудитын хамрах хүрээ .....	3
Үндсэн мэдээлэл .....	3
Эрсдэлийн үнэлгээ.....	4
Аудитын арга зүй.....	4
Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд.....	5
Аудит хийх багийн бүрэлдэхүүн.....	5
Аудитын хугацаа .....	6
Аудитын хөтөлбөр.....	6
Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц.....	6

Хавсралт 1. Аудитын эрсдэлийн үнэлгээ

Хавсралт 2. Асуудлын шинжилгээ

Хавсралт 3. Аудитын нотлох зүйл цуглуулах арга зүй

Хавсралт 4. Аудитын хөтөлбөр

Хавсралт 5. Үр өгөөжийн төлөвлөлт

БАТЛАВ.  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ОРЛОГЧ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.ТЭНГИС

### АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

#### Аудитын иэр

Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2017-2020 онд зарцуулсан хөрөнгийн ашиглалт, үр нөлөө

#### Аудитын код

ГАГ-2020/13-ГА

#### Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг “Аудитын сэдэв батлах тухай” Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 4 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

#### Аудитын зорилт

Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2017-2020 онд зарцуулсан хөрөнгийн ашиглалт, үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааны санхүүжилт, төсөвт төвлөрүүлэх орлогыг хууль, журмын дагуу бүрдүүлсэн эсэх,
- Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ үр нөлөөтэй эсэх.

#### Аудитын хамрах хүрээ

Аудитад Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор баталсан “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлт, үр дүнг тооцох, тайллагнах үүрэг хүлээсэн Төрийн захиргааны төв байгууллага, тэдгээрийн харьяа агентлагууд, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, түүний ажлын алба, Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар, холбогдох бусад байгууллагуудыг хамруулна.

#### Үндсэн мэдээлэл

Сүүлийн жилүүдэд хот, суурин газрын хүн ам, автомашины тоо өсөж, үйлдвэрлэл, үйлчилгээ нэмэгдэхийн хирээр агаар, орчны бохирдлын түвшин зөвшөөрөгдхөн хэмжээнээс хэтэрсний улмаас хотын хүн ам, ялангуяа хүүхэд, өндөр настны дунд агаарын бохирдлоос шалтгаалсан амьсгалын болон зүрх судасны тогтолцооны өвчлөл, нас баралт ихэсч байгааг эрүүл мэндийн байгууллагуудын судалгаанд дурджаа.

Иймд агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн ойрын хугацаанд үр дүнд хүрэх, бодитой үйл ажиллагааг тодорхойлсон нэгдсэн бодлого боловсруулж, техник, технологи, хөрөнгө

санхүү, хүний нөөцийн бүхий л боломжийг ашиглан салбар дундын нэгдсэн зохицуулалтыг ханган хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага бий болсон байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлэх” зорилтыг дэвшүүлж, агаарын бохирдлыг бууруулах үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасныг үндэслэн Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг баталсан байна.

Тус хөтөлбөр нь “Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн бохирдлын эх үүсвэрийг багасгаж, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлэх замаар агаар, орчны бохирдлыг бууруулж эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх” зорилготой бөгөөд зорилгыг хангахын тулд 5 зорилтын хүрээнд 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Хөтөлбөрийг 2017-2019 он, 2020-2025 он гэсэн 2 үе шатаар хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжилтийг 2016 оны жилийн эцсийн үзүүлэлтийг суурь болгон ашиглаж, 25 шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр тусгасан байна.

Агаарын бохирдлыг бууруулахад 2017-2019 онд улсын төсвөөс 168.9 тэрбум төгрөг, АХБ, ЕХОБ, Дэлхийн банк, БНХАУ-ын зээлээр 167.1 тэрбум төгрөг, Нийслэлийн төсвөөс 32.0 тэрбум төгрөг, нийт 368.0 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

ҮАГ-аас 2018 онд “Цэвэр агаарын сан болон 2008-2016 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгөөр хийгдсэн ажлын үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар “Улаанбаатар хотод агаар, ус, хөрсний бохирдол холбогдох стандарт хэмжээнээс хэтэрч гамшгийн түвшинд хүрсэн, тоос шороо, хог хаягдал, автомашины түгжрэл, дуу чимээ зөвшөөрөгдхөх хэмжээнээс хэтрэх эрсдэл үүсэж, хүн амын төвлөрөл нэмэгдэж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т заасан иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх ноцтойгоор зөрчигдэж байгаа тул онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна” гэсэн асуудлыг УИХ-ын анхааралд толилуулсан байна.

Мөн Монгол Улсын Ерөнхий сайд, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны даргад 5, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад 3, Сангийн сайдад 2 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид агаар, орчны бохирдол ёсож байгааг “царцаах болон бууруулах” нэгдсэн бодлогын хүрээнд эхний үе шатанд 8 арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх, хоёр дахь үе шатанд 8 арга хэмжээг хэрэгжүүлэхийг зөвлөсөн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны 03/3276 дугаар албан бичгээр зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайланг ирүүлсэн бөгөөд аудитын явцад зөвлөмжийн үр дүнг тооцох болно.

### Эрсдэлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн үе шатны явцад судалсан баримт материал, урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “ДУНД” гэж үнэлсэн.

### Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000, Төрийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны A/92 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ыг баримтлан “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”, түүнийг хэрэгжүүлэх төлевлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх Төрийн захиргааны төв байгууллагууд, тэдгээрийн харьяа агентлаг, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, Нийслэлийн Засаг дарга, түүний харьяа байгууллагуудын агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагaa болон судалгаа авах, тулган баталгаажуулах, харьцуулах, нэгтгэх, дүн

шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

### **Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд**

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

- Агаарын тухай хууль
- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Усны тухай хууль
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
- Хог хаягдлын тухай хууль
- Химиин хорт болон аюултай бодисын тухай хууль
- Эрүүл ахуйн тухай хууль
- УИХ-ын 2010 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Ус” үндэсний хөтөлбөр
- УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”
- УИХ-ын 2011 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр”
- УИХ-ын 2018 оны 02 дугаар тогтоол “Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2011 оны 309 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний үнийн урамшуулалт олгох журам”, “Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулалт олгох журам”
- Засгийн газрын 2012 оны 227 дугаар тогтоолоор баталсан “Агаарын бохирдлын төлбөрөөс бүрэн чөлөөлөх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт”, “Агаарын бохирдлын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт”
- Засгийн газрын 2016 оны 214 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн гэр хорооллын өрхөд цахилгааны тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”
- Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолоор баталсан “Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”
- Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор баталсан “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”
- Засгийн газрын 2018 оны 157 дугаар тогтоолоор баталсан “Гаалийн албан татвар, Нэмэгдсэн өргтийн албан татвараас чөлөөлөх агаар цэвэршүүлэгч, эрчим хүчний хэмнэлттэй халаагч төхөөрөмжийн жагсаалт”, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Засгийн газрын 2019 оны 461 дүгээр тогтоол
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

### **Аудит хийх багийн бүрэлдэхүүн**

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор С.Оюунгэрэл хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер З.Ариунзаяа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Долгорсүрэн, аудитор Б.Анхбаатар, М. Баяртготох, Ү.Төгсжаргал нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэнэ.

Аудитын багт агаар, орчны бохирдлыг хэмжих, судалгаа, дүн шинжилгээ хийх зөвлөх, шинжээч ажиллуулна.

### Аудитын хугацаа

Аудитын урьдчилсан судалгаа, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор гүйцэтгэж, аудитын төлөвлөгөөг Монгол Улсын Ерөнхий аудитороор батлуулна.

Аудитын талбарын үе шатны ажлыг 2020 оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл, тайлагналын үе шатны ажлыг 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 4 дүгээр сарын 15-ны дотор Монгол Улсын Ерөнхий аудитороор батлуулж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон УИХ-ын Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

### Аудитын хөтөлбөр

Асуудлын шинжилгээнд тусгагдсан асуудлаар багийн гишүүдийн гүйцэтгэх ажлыг хуваарилж, аудитын хөтөлбөрт тусгав.

### Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

Аудитад шаардагдах зардлын төсөв, түүний тооцоолол. Үүнд:

А. Боловсон хүчин: ҮАГ-аас 5 хүн х 244 хүн/өдөр = 1220 хүн өдөр

Б. Санхүүгийн нөөц: Аудитын зардал 242.8 мянган төгрөг \*1220 өдөр = 296,216.0 мянган төгрөг, Зөвлөх шинжээчийн ажлын хөлс 25,000.0 мянган төгрөг, нийт 321,216.0 мянган төгрөг.

В. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, диктафон, зургийн аппарат, бусад техник хэрэгсэл.

Аудитын төлөвлөгөөг хянасан:

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТИН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТИН МЕНЕЖЕР

  
С.ОЮУНГЭРЭЛ

  
З.АРИУНЗАЯА

Боловсруулсан:

АХЛАХ АУДИТОР

  
Б.ДОЛГОРСҮРЭН

АУДИТОР

  
М.БАЯРТОГТОХ

  
Ү.ТӨГСЖАРГАЛ

2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр